

МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИИ  
ХООРОНДЫН "УХААЛАГ ЗАСАГ-2 ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ  
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ

2023 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд зэ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн талаарх 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тус Байнгын хорооны санал, дүгнэлтээр Засгийн газарт чиглэл болгож хүргүүлсэн үүргээс дөрвийг нь тусгаагүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй гэдгийг ажлын хэсэгт анхааруулсан болно. Тухайлбал:

**1. Гэрээний хуваарь №1, Бүрэлдэхүүн хэсэг 1: "Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх"** гэсэн хэсэгт дараах зүйлийг нэмж тусгах:

- Дижитал шилжилтийн үндэс болох кибер аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн ажил арга, хэмжээг авч хэрэгжүүлэх;

- Кибер аюулгүй байдлын тухай багц хуулийг дагалдан гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцаанд орж буй төр, хувийн хэвшлийн байгууллагуудын алба хаагчдыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, ялангуяа онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагын ажилтан, алба хаагчдад зориулсан сургалт, хетөлбөрийг шат дараатай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

**2. Гэрээний хуваарь №1, Бүрэлдэхүүн хэсэг 2: "Дижитал засгийн шилжилт"** гэсэн хэсэгт дараах зүйлийг нэмж тусгах:

- Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын кибер аюулгүй байдлын түвшинг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, алба хаагчдыг сургах, чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

**3. Гэрээний хуваарь №1, Бүрэлдэхүүн хэсэг 2: "Дижитал засгийн шилжилт" 2.3 дугаар зүйлийн (а) хэсэгт** Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв болон Нэгдсэн төвийг

байгуулахад шаардлагатай тоног тухеөрөмж, программ хангамж авах, төвүүдийн хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх" гэж нэмэх;

4. Гэрээний хуваарь №1, Бүрэлдэхүүн хэсэг 3: "Дижитал здийн засгийн хөгжлийг дэмжих" 3.1 дүгээр зүйлийн (а, б, в, г, д) хэсэгт заасан зүйлсийг бүхэлд нь өөрчилж, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлд заасан Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 216 байгууллага, 4.1.17-д заасан Терийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон 166 байгууллагын ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэж нэмэх гэсэн асуудлуудыг тусгах.


Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, 81.8 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Ухаалаг засаг-2 тесел"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төрийн өрдөн;  
Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны Q1 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан "Ухаалаг засаг II төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын усэг